Авлага дансны үлдэгдэл 75,017.08 мянган төгрөг болж 70,006.48 мянган төгрөгөөр өссөн нь цалин болон НДШ, бусад зардлын тооцооны гүйлгээг хийгээгүй байхад Сангийн яам татсанаас авлага нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд 2002-2003 онуудад үүссэн, он удаан жил болсон хувь хүнээс авах авлага 3,789.1 мянга, бусад зардлын тооцооны 1,221.6 мянга нийт 5,010.6 мянган төгрөгийн авлага байна.

Нийт авлагаас баргадах боломжгүй эрсдэлтэй 5,010.6 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй авлага үүсэх үр дагавартай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 314,155.25 мянган төгрөг болж 109,148.55 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 185,207.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,233,678.4 мянган төгрөгийн барааг хандиваар, 41,346.6 мянган төгрөгийн барааг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Оны эцэст түргэвчилсэн оношлуурын төлбөр 84,693.0 мянга, нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын 15,881.6 мянга, нийт 100,574.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Ковид-19 цар тахлын бэлэн байдлыг хангахтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,722,933.4 мянган төгрөг болж 122,263.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 153,682.6 мянган төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 21,202.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 10,276.9 мянган төгрөг, нийт 31,478.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө тайлант онд бүртгэгдээгүй байна.

Бусад үндсэн хөрөнгө 28,862.0 мянга, программ хангамж 8,332.7 мянга, бусад биет бус хөрөнгө 497,495.0 мянган төгрөгийн хөрөнгөд тайлант онд өөрчлөлт ороогүй.

Өр төлбөр дансны үлдэгдэл 70,006.46 мянган төгрөг болж 70,006.46 мянган төгрөгөөр өссөн нь 2020 оны 12 дугаар сард зарим гүйлгээг хийгдээгүй байхад Сангийн яамнаас дансны үлдэгдлийг татсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,574,782.6 мянган төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,445,762.2 мянган төгрөгөөр буюу 85.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь санхүүжилтийн орлого 663,209.6 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 847,846.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,073,457.8 мянган төгрөгөөр буюу 82.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нормативт зардал, тэтгэмжийн зардлууд байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,253,705.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,253,705.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 179,958.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,433,663.7 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,570.0 мянга нийт 1,435,233.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй нь эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 98,580.0 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 10,573.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 6,250.6 мянга, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг 156,551.7 мянган төгрөгөөр нэмж баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,435,233.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,433,663.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 1,570.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,433,663.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 1,570.0 мянган төгрөг, нийт 1,435,233.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,412,823.8 мянган төгрөгийг зарцуулж 24,518.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,412,823.8 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 5,332.3 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 15,881.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,117.9 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Засгийн газрын нөөц сан 139,994.4 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 230,151.7 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,320.0 мянга, хандив тусламж 17,638.2 мянга нийт 389,104.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин урамшуулалд 149,009.8 мянга, хангамж бараа материалын зардалд 2,032.8 мянга, нормативт зардалд 60,110.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 29,570.2 мянга, бусад урсгал шилжүүлэг 73,206.7 мянга нийт 313,930.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 70,510.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

**<u>Ковид-19 цар тахал</u>**: Эрүүл мэндийн яамнаас Ковид-19 цар тахалтай тэмцэхэд халдварын голомтот бүсэд үүрэг гүйцэтгэж буй эмч, эмнэлгийн ажилтнуудад урамшуулал, илүү цагийн хөлс 228,650.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хувийн хэвшлийн эмнэлгээс 2,700.0 мянга, шүдний холбооноос 3,000.0 мянга нийт 5,700.0 мянган төгрөгийн хандив авсан.

Короновирусын халдварын сэргийлэлт, хяналтын сургалтын зардалд 5,509.5 мянга, халдвар хамгааллын хэрэгсэл 3,263.6 мянга, нийт 8,773.1 мянган төгрөг зарцуулсан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах,

удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилт бүртгэгдээгүй байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,754,387.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,328.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 132.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 4,816.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 4,735,753.4 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулахаар 1 албан шаардлага, 6,357.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн 870.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн.
2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардал 5,782.7 мянгаар буруу илэрхийлэгдсэн.
3. Хоол хүнсний зардал 675.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэнийг тус тус аудитын явцад залруулга хийсэн.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4,747,059.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 132.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,816.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4,735,753.4 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах санал хүргүүллээ. Үүнд:

1. Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар үндсэн цалингийн 40% буюу 316.6 мянган төгрөгөөр шагнасан, нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 65 тоот төлбөрийн хүсэлтээр Эрүүл мэндийн салбарын ажилчдын В вирусын шинжилгээний төлбөр 4,500.0 мянган төгрөг, нийт 4,816.6 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн “Эдийн засгийн ангилал” батлах тухай 55 дугаар тушаалын “210101-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин, 210102-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд, тухайлбал онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана” заалттай нийцэхгүй, иж бүрэн байдал, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
   <u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан шаардлага хүргүүлэв.
2. Байгууллагын ажилтнуудад илүү цагийн хөлс олгохдоо 2020 оны 02 сард 31.5 мянга, 2020 оны 06 сард 100.6 мянга нийт 132.1 мянган төгрөгийн илүү цаг ажилласны хөлсийг 2 ажилтанд буруу, илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д

"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" заалттай нийцэхгүй, иж бүрэн байдал, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Тус байгууллага нь 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр санхүүгийн тайлан, бусад шаардлагатай харилцахын баримт, материалыг ирүүлэхдээ тээвэр шатахуун, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, байгууллагын нярав нь 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр архивын нэгж болгож үдээгүй задгай, эмх цэгцгүй баримт авчирсан нь аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, албан үүргээ биелүүлээгүй нь Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д " шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах" заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,357.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Балансын данстай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Цалингийн өглөг 36,251.8 мянга, НДШ-ийн өглөг 12,867.3 мянга, шуудан холбооны өглөг 180.0 мянга, хоолны өглөг 400.0 мянга, эмийн өглөг 5,959.0 мянга, байгууллагад өгөх өглөг 11,548.3 мянга, хувь хүмүүст өгөх өглөг 2,800.0 нийт 70,006.5 мянган төгрөгийн өглөг нэмж бүртгэгдсэн бол авлага дансанд бусад зардлын тооцооны авлага 71,228.03 мянган төгрөгөөр нэмэгдэж 75,017.1 мянга болсон.

1.2. *Эрсдэл:*Найдваргүй авлага үүсэх

*1.3. Өгсөн зөвлөмж:Төсвийн тухай хуулийн 6.4.8 дах заалтын дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*

*1.4.* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/166 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

*2.Шилэн данстай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй байна.

*2.2. Эрсдэл*: Ашиг сонирхлын зөрчил үүсэх

*2.3. Өгсөн зөвлөмж:* Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж, баталгаажуулж, шилэн дансанд мэдээлж байх.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/166 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

*3.Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 5 дугаар сарын 11-ны өдөр “Голден мед” ХХК-аас халдвар хамгааллын хэрэгсэл худалдан авахдаа нэг удаагийн маскыг зах зээлийн үнээс өндрөөр буюу нэг ширхгийг нь 800 төгрөгөөр 500 ш-ийг нийт 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан.

*3.2. Эрсдэл*: Ашиг сонирхлын зөрчил үүсэх, төсөвт үрэлгэн хандах

*3.3. Өгсөн зөвлөмж:*Бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа зах зээлийн үнэтэй уялдуулан судалгаа тооцоолол хийж байх

*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/166 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

*4 Зардлын данстай холбоотой асуудал*

*4.1 Илрүүлэлт:* Байгууллагын өмнөх удирдлага 2020.03 сард эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүй, аймгийн засаг даргын эрүүл мэндийн газрын нягтланд хуулийн хүрээнд зохион байгуулах гэсэн цохолттой албан бичгийг үндэслэн өөртөө 102 цагийн илүү цагийн хөлс 946.4 мянган төгрөгийг авсан.

*4.2. Эрсдэл*: Ашиг сонирхлын зөрчил үүсэх

*4.3. Өгсөн зөвлөмж:*Төсвийн шууд захирагч нь удирдах дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн цалин урамшууллыг бодож байх.

*Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/166 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР: Т.БОЛОРМАА

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | |
|---|---|
| Огноо: | 2020 |
| Аудитын нэр: | *Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит* |
| Аудитын код: | ОРА-2021/3/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | **Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар** |
| Мянган төгрөгөөр | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдвэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар үндсэн цалингийн 40% буюу 316.6 мянган төгрөгөөр шагнасан, нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 65 тоот төлбөрийн хүсэлтээр Эрүүл мэндийн салбарын ажилчдын В вирусын шинжилгээний төлбөр 4,500.0 мянган төгрөг, нийт 4,816.6 мянган төгрөгийг олгосон. | 4,816.6 | Албан шаардлага | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| 2 | Байгууллагаас илүү цагийн хөлс бодож олгохдоо 2020 оны 02 сард 31.5 мянга, 2020 оны 06 сард 100.6 мянган төгрөгийн илүү цаг ажилласны хөлсийг 2 ажилтанд буруу, илүү тооцоолж олгосон. | 132.1 | Төлбөрийн акт | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| 3 | Тус байгууллага нь 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр санхүүгийн тайлан, бусад шаардлагатай харилцахын баримт, материалыг ирүүлэхдээ тээвэр шатахуун, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, байгууллагын нярав нь 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр архивын нэгж болгож үдээгүй задгай, эмх цэгцгүй баримт авчирсан нь аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, албан үүргээ биелүүлээгүй. | 4,735,753.4 | Сахилгын шийтгэл тооцуулах | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| 4 | Цалингийн өглөг 36,251.8 мянга, НДШ-ийн өглөг 12,867.3 мянга, шуудан холбооны өглөг 180.0 мянга, хоолны өглөг 400.0 мянга, эмийн өглөг 5,959.0 мянга, байгууллагад өгөх өглөг 11,548.3 мянга, хувь хүмүүст өгөх өглөг 2,800.0 нийт 70,006.5 мянган төгрөгийн өглөг нэмж бүртгэгдсэн бол | 5,010.6 | Зөвлөмж | Даргын үүргийг түр орлон | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | авлага дансанд бусад зардлын тооцооны авлага 71,228.03 мянган төгрөгөөр нэмэгдэж 75,017.1 мянга болсон. | | | гүйцэтгэгч, Нягтлан бодогч | |
| 5 | Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй | | Зөвлөмж | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| 6 | Нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 5 дугаар сарын 11-ны өдөр “Голден мед” ХХК-аас халдвар хамгаалллын хэрэгсэл худалдан авахдаа нэг удаагийн маскыг зах зээлийн үнээс өндрөөр буюу нэг ширхэгийг нь 800 төгрөгөөр 500 ш-ийг нийт 400.0 мянган төгрөгөөр худалдан авсан. | 400.0 | Зөвлөмж | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| 7 | Байгууллагын өмнөх удирдлага 2020.03 сард эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүй, аймгийн засаг даргын эрүүл мэндийн газрын нягтланд хуулийн хүрээнд зохион байгуулах гэсэн цохолттой албан бичгийг үндэслэн өөртөө 102 цагийн илүү цагийн хөлс 946.4 мянган төгрөгийг авсан. | 946.4 | Зөвлөмж | Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Нягтлан бодогч | Д.Сүхээ, Н.Чулуун-Эрдэнэ |
| **ДҮН** | | **4,747,059.1** | | | |

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР: Т.БОЛОРМАА

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 07/07 ОАА-2021/03/СТА-ТШЗ Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын ажилтнуудад илүү цагийн хөлс олгохдоо 2020 оны 02 сард 31.5 мянга, 2020 оны 06 сард 100.6 мянган төгрөг, нийт 132.1 мянган төгрөгийн илүү цаг ажилласны хөлсийг 2 ажилтанд буруу, илүү тооцоолж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтоохад дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын илүү олгосон илүү цагийн хөлс 132.1 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн засаг даргын Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Сүхээ, нягтлан бодогч Н.Чулуун-Эрдэнэ нарт хариуцуулав.

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.................................Т.БОЛОРМАА

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 13/12 ОРА-2021/03/СТА-ТШЗ Эрдэнэт

## САХИЛГЫН ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/66 тоот албан бичгээр санхүүгийн тайлан, бусад шаардлагатай харилцахын баримт, материалыг ирүүлэхдээ тээвэр шатахуун, үндсэн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийн анхан шатны баримтыг Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, нярав Л.Даваажав нь 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдөр архивын нэгж болгож үдээгүй задгай, эмх цэгцгүй баримт авчирсан нь аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, албан үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д " шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг хэлбэрээс нь үл хамааран шалгагдагч этгээд, аудитад хамрагдагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хугацаанд, үнэ төлбөргүйгээр гаргуулах, хуулбарлаж авах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын нярав Л.Даваажав, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга болон гишүүд нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Сүхээ, нягтлан бодогч Н.Чулуун-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:....................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР....................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР....................................Т.БОЛОРМАА

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 13/13 ОРА-2021/03/СТА-ТШЗ Эрдэнэт

## ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2020 оны үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас байгууллагын даргын 2020 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн Б/04 дүгээр тушаалаар үндсэн цалингийн 40% буюу 316.6 мянган төгрөгөөр шагнасан, нэмэлт санхүүжилтийн данснаас 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 65 тоот төлбөрийн хүсэлтээр Эрүүл мэндийн салбарын ажилчдын В вирусын шинжилгээний төлбөр 4,500.0 мянган төгрөг, нийт 4,816.6 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн "Эдийн засгийн ангилал" батлах тухай 55 дугаар тушаалын "210101-Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин, 210102-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд, тухайлбал онцгой нөхцөлийн, ажилласан хугацааны, зэрэг дэвийн, мэргэжлийн зэргийн, ур чадварын, дэвтэр зассан, анги удирдсан, цолны цалин гэх мэт үндсэн цалингаас хувиар бодож буюу үнэмлэхүй хэмжээгээр тогтоон олгож байгаа нэмэгдлүүд багтана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар нь үндсэн цалин болон нэмэгдэл цалингийн сангаас шагналд 316.6 мянган төгрөг, эрүүл мэндийн үзлэгт 4,500.0 мянга, нийт 4,816.6 мянган төгрөг олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч Д.Сүхээ, нягтлан бодогч Н.Чулуун-Эрдэнэ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..............................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..............................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..............................Т.БОЛОРМАА